




ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
05 тоот тушаалын 09 дүгээр хавсралт



**ТРАСТ ФИНАНС БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО**



ГУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
05 тоот тушаалын 09 дүгээр хавсралт


<i>Хамрах хүрээ:</i> Трастфинанс ББСБ	<i>Хариуцах эзэн:</i> ТРАСТФИНАНС ББСБ ХХК дотоод хяналт болон дотоод аудитын газар
<i>Хувийг хадгалах:</i> Гүйцэтгэх захирал	<i>Танилцах:</i> ТРАСТФИНАНС ББСБ ХХК-н ажилтнууд
<i>Хүчинтэй хугацаа:</i> 2023.10.10	<i>Хуудасны тоо:</i> 6

Өөрчлөлтийн түүх:

№	Хувилбар	Өөрчлөлт хийгдсэн огноо	Өөрчлөлтийн агуулга
1			
2			
3			
4			
5			
6			
7			



ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
05 тоот тушаалын 09 дүгээр хавсралт



БОДЛОГЫН ТОВЬЁОГ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР.ХАМГААЛАЛТЫН БҮС

ГУРАВ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА



ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
05 тоот тушаалын 09 дүгээр хавсралт

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү бодлого нь “Трастфинанс ББСБ” ХХК /цаашид ББСБ гэх/-ийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, бизнесийн үндсэн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар хүлээж болзошгүй алдагдалыг бууруулах, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг ханган ажиллах үр дүнтэй, үр ашигтай хяналтын тогтолцоог бий болгож хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.2. ББСБ нь хамгаалалтын хоёр бүсийн зарчимд тулгуурлан эрсдэлийн оновчтой удирдлагыг хэрэгжүүлэн ажиллах бөгөөд хамгаалалтын бүсүүдийн чиг үүрэг, хариуцлагыг эрсдэлийн төрөл бүрээр тодорхойлсон байна.
- 1.3. Гүйцэтгэх захирал нь ББСБ-н эрсдэлийн төрөл болон тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулсан журмуудыг батлан гаргаж хэрэгжүүлэх ба тэдгээр энэхүү бодлогын салшгүй нэг хэсэг байна.

ХОЁР. ХАМГААЛАЛТЫН БҮС

- 2.1. ББСБ-н эрсдэлийн тогтолцоо нь хамгаалалтын гурван бүсийн зарчимд тулгуурлах ба тэдгээр нь дараах чиг үүрэгтэй байна
 - 2.1.1 **Хамгаалалтын нэгдүгээр бүс:** Бизнес болон түүнд дэмжлэг үзүүлэгч нэгжүүд байх бөгөөд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллана. Өөрөөр хэлбэл өөрийн хариуцаж буй бизнесийн эрсдэлийг үнэлэх, хянах, тайлагнах бууруулж ажиллах чиг үүрэгтэй.
 - 2.1.2 **Хамгаалалтын хоёрдугаар бүс:** Эрсдэл хуулийн газар байх бөгөөд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажиллана.
 - 2.1.3 **Хамгаалалтын гуравдугаар бүс:** Дотоод аудит болон дотоод хяналтын алба нэгж Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлагад хараат бус мэдээлэлийг өгөх ба хамгаалалтын нэгдүгээр бүсийн үйл ажиллагааны үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.


ГУРАВ. ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ

- 3.1. ББСБ-д учирч болох эрсдэлийг дараах байдлаар ангилна. Үүнд:
 - 3.1.1. **Зээлийн эрсдэл:** Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүйн улмаас хүлээж болзошгүй алдагдал.
 - 3.1.2. **Зээлийн төвлөрөлийн эрсдэл:** Нэг болон харилцан хамааралтай зээлдэгч эсвэл нэг салбарт зээлийг төвлөрүүлж олгосны улмаас үүсэх эрсдэл.
 - 3.1.3. **Зах зээлийн эрсдэл:** Зах зээл эдийн засгийн хямрал, ханш хүү, инфляцын огцом өөрчлөлтөөс шалтгаалан орлого болон хөрөнгийн хэмжээнд хүлээж болзошгүй эрсдэл.
 - 3.1.4. **Хөрвөх чадварын эрсдэл:** Өөрийн хөрөнгийн хүрэлцээ алдагдаагүй боловч харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэх чадваргүй болох
 - 3.1.5. **Үйл ажиллагааны эрсдэл:** Дотоод процесс, хүний нөөц болон системийн үйл ажиллагаа хангалтгүй буюу доголдолтой, эсвэл гаднын хүчин зүйлсийн улмаас хүлээж болзошгүй алдагдал. Хууль эрх зүйн эрсдэл нь үйл ажиллагааны эрсдэлд хамаарана.
 - 3.1.6. **Аюулгүй байдлын эрсдэл:** Бодит болон мэдээлэлийн аюулгүй байдал алдагдсанаас үүсэх гарз хохирол.
 - 3.1.7. **Ёс зүйн эрсдэл:** Ёс зүйн дүрмийг зөрчсөн эсвэл харилцагчтай шударга харилцах зарчмыг хэрэгжүүлээгүйн улмаас гарч болзошгүй алдагдал.

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.



ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
05 тоот тушаалын 09 дүгээр хавсралт



3.1.8. **Нэр хүндийн эрсдэл:** Олон нийтийн сөрөг ойлголтоос үүдэн байгууллагын нэр хүндэд хохирол учрах улмаар орлого буурах эрсдэл.

3.2. Хамгаалалтын нэг болон хоёрдугаар бүсүүд нь дараах байдлаар эрсдэлийн төрлүүдэд хувиарлагдана.

Эрсдэлийн төрөл	Хамгаалалтын бүс 1	Хамгаалалтын бүс 2
Зээлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрдэлийн удирдлагын нэгж
Зээлийн төвлөрөлийн эрсдэл	Бизнесийн нэгжүүд	Эрдэлийн удирдлагын нэгж
Зах зээлийн эрсдэл	Санхүү удирдлага хөрөнгө зохицуулалтын нэгж	Эрдэлийн удирдлагын нэгж
Хөрвөх чадварын эрсдэл	Санхүү удирдлага хөрөнгө зохицуулалтын нэгж	Эрдэлийн удирдлагын нэгж
Үйл ажиллагааны эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрдэлийн удирдлагын нэгж
Аюулгүй байдлын эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрдэлийн удирдлагын нэгж
Ёс зүйн эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрдэлийн удирдлагын нэгж
Нэр хүндийн эрсдэл	Бүх нэгжүүд	Хууль, эрдэлийн удирдлагын нэгж

ДӨРӨВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 4.1. ТУЗ нь байгууллагын үйл ажиллагааны бүхий л чиглэлийг эрсдэлийн удирдлагаар хангаж, нэгдсэн үйл ажиллагааг хариуцан, дотооддоо мөрдөх зааврыг байгууллагын бизнесийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлог, бүтэц, зохион байгуулалтад нийцүүлэн батална.
- 4.2. Заавраар байгууллагын зорилго, зорилгод нөлөөлөх эрсдэл, ирээдүйд тохиолдох магадлал ба нөлөөллийг үнэлснээр эрсдэлд хариу өгөх арга хэмжээ, түүнийг үнэлэх үйл явцад мониторинг хийх зэрэг эрсдэлийн удирдлагын хүрээг тодорхойлно.
- 4.3. ТУЗ нь зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн хороо, байхгүй бол Аудитын хороо нь байгууллагын эрсдэлийн удирдлага, түүний хэрэгжилтэд хяналт тавина.
- 4.4. Энэхүү баримт бичгийг цаг үедээ тохируулан тухай бүр шинэчлэн батална.

ТАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

- 5.1 Эрсдэлийг тодорхойлох: тулгарч буй хүндрэлийг шийдвэрлэх болон бизнесийн цар хүрээг нэмэгдүүлэх, гуравдагч талын харилцаа, зах зээлээс хамаарсан, эсхүл зохицуулалтын орчинд гарсан өөрчлөлт зэргээс

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.



ТУЗ-ийн 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн
05 тоот тушаалын 09 дүгээр хавсралт

үүсэх магадлалтай эрсдэлийг байгууллагын бүхий л түвшинд тодорхойлно. Ингэхдээ дараах хүчин зүйлсийг харгалзана:

- 5.1.1 эрсдэлийн шинж чанар /nature of the risk/ - хаана, хэзээ, ямар үйл явдал;
 - 5.1.2 эрсдэлийн эх үүсвэр /source of the risk/ - ямар хүчин зүйлс, хүн, үйл ажиллагаа;
 - 5.1.3 эрсдэлийн шалтгаан /cause of the risk/ - шууд болон шууд бус шалтгаан;
 - 5.1.4 эрсдэлийн нөлөө /effect of the risk/ - үүсэх үр дагавар, хамгийн сөрөг нөлөө.
- 5.2 Эрсдэлийг үнэлэх: эрсдэлийн нөлөөллийн хүчин зүйлсийг ялгаж харах зорилгоор ач холбогдлын түвшингээр нь ангилж, үнэлэх ба эрсдэлийг хэмжихэд ашиглаж буй арга зөв эсэхийг тогтмол шалгана. Эрсдэлийг чанарын болон тоон хэрэгслүүдийг ашиглан үнэлнэ.
- 5.3 Эрсдэлийг удирдах: эрсдэлийн үнэлгээний үр дүнд эрсдэлд үзүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох ба эрсдэлийн удирдлагын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

ЗУРГАА. БУСАД

- 6.1 Гүйцэтгэх удирдлага нь эрсдэлийн удирдлагын зааврын хүрээнд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөө боловсруулж, байгууллагын эрсдэлийг тодорхойлон үнэлж, удирдах үйл ажиллагааг явуулна.
- 6.2 Гүйцэтгэх удирдлагын дэргэд байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэх эрсдэлийн удирдлагын нэгж, эсхүл ажилтан байх бөгөөд бусад гүйцэтгэх шатны удирдлагуудтай байнгын харилцан холбоотой ажиллана.
- 6.3 Гүйцэтгэх удирдлага эрсдэлийн удирдлагын нэгж эсхүл ажилтнаар дамжуулан эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө тухайн байгууллагад нийцсэн үр дүнтэй эсэх, төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана

Энэхүү баримт бичиг нь Траст финанс ББСБ өмч болно.